ХЯТАД ХЭЛНИЙ ЯЗГУУР ҮЕИЙГ МОНГОЛООР ГАЛИГЛАХ ТУХАЙД

Г.БИЛГҮҮДЭЙ*

Монголчууд Хятад оронтой олон зуун жил хөрш зэргэлдээ оршин эдийн болон соёлын өргөн дэлгэр харилцаа холбоотой явж ирсний хувьд хятад хэлний зарим нэр, үгийг монгол бичгээрээ тэмдэглэсээр ирсэн нь чухамдаа хятад хэлний авиаг өөрийн төрөлх хэл, монгол бичгээр галиглан хэрэглэх системтэй арга боловсруулан хэрэглэж байжээ. Гэтэл монгол бичгээр хятад хэлний авиаг тэмдэглэж болдог бэлээхэн систем байсаар байтал үүнийгээ ашиглаж мэдэхгүй хятад үг, нэрийг монгол шинэ үсгээр буулгахдаа ихээхэн буруу зөрүү, системгүй буулгах явдал тохиолдсоор байна. Үүнд хоёр шалтгаан байгаа бололтой. Нэгд хятад нэр, үгийг оросын галиглах системийг шууд хуулбарлан авах замаар буулгадаг, хоёрт монгол бичгээр зөв галиглан бичсэн зүйлийг шинэ кирилл үсэгт буулгахдаа системийн дагуу буулгадаггүй өөрсдийн уншсан ухаарснаар дур мэдэн буулгадгаас болдог байна. Тухайлбал, монголчууд хятад нутагт байгуулсан их гүрнээ Yuan гэж нэрлэжээ. Үүнийг зүй нь Юань гэж буулгах ёстой байтал Монгол улсын түүхийн ботид Юан гэж буруу бичсэн зүйл тохиолдож байна. Хятадын түүхэн зүтгэлтэн, "Гурван улсын үлгэр" зохиолын баатар Цао Цаог монгол бичгийн галигт 曹操 гэж галигладаг бөгөөд үүнийг монгол бичгийн давхар эгшгийн ёсоор ойлгон Цоу Цоу гэх мэт буруу буулгах явдал мэр сэр гарсаар байна.

Хятадын эртний дүрс утгын бичгийг галиглан тэмдэглэх аргын боломж нь хятад хэлэнд өөрт нь агуулагддаг байна. Хятад хэлний авиазүйн үндсэн нэгж нь үе болно. Энэ үе нь эгшиг, заримдаг эгшиг, гийгүүлэгч авианы тодорхой дарааллаас бүрдэл болдог байна. Хятад хэлний үе нь үеийн эхний гийгүүлэгч, үе болдоггүй эгшиг, үе болдог эгшиг, үеийн төгсгөлийн гийгүүлэгч юмуу эсвэл заримдаг эгшиг гэсэн ийм дөрвөн бүтвэрийн оролцоотойгоор бий болдог байна. Үеийн бүтвэрүүдийн хатуу тогтсон дараалал, энэ бүтвэр бүрийн үүргээр орж чадах авианы тооны хязгаар зэрэг нь орчин цагийн хятад үндэстний хэлэнд харьцангуй цөөн гэж болох 400 гаран язгуур үеийг бий болгодог байна. Хятад хэлний авиа зүйн байгуулалтын энэ онцлог нь хятад хэлний авиаг монгол бичгийн үсгээр галиглах зарчим, арга зүйн үндэс болж өгдөг байна.

Хятад хэлний авиа зүйн онцлог нь бусад орны хэл бичгээр ч галиглан буулгах үндэс нь болдог байна. Хятад хэлний үгийг англиар галиглах олон систем гарчээ. Тухайлбал Баллер (Baller), Бонни (Bonney), Брижмэн (Bridgeman), Годдард (Goddard), Жайлс (Giles), Женкинс (Jenkins), Ейтс

* Г. БИЛГҮҮДЭЙ -ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D), профессор

(Yates), Матир (Mateer), Моррисон (Morrison), Стент (Stent), Уильямс (Williams), Уэйд (Wade) нарын галиглах систем байдаг байна. Ихэнхи системийн бичлэг нь давхцаж байдаг ба ялгаатай өвөрмөц хэсэг нь бараг хэрэглэдэггүй байна. Дээр нэр гарсан олон галигийн системээс хамгийн их дэлгэрсэн нь Уэйдийнх бөгөөд энэ системийг бас Уэйд-Жайлсын гэж ч нэрлэгдэг байна. Англи галигийн системийн гол зүйл нь хятад хэлний дуутай сул болон дуугүй чанга гийгүүлэгчийг адил үсгээр тэмдэглээд дуугүй чанга гийгүүлэгчийг ялгах тэмдэг "апостроф"-оор ялгаж өгсөнд байдаг. Тэрнь: ch=ж, ch'=ч; k=г, k'=к; p=б, p'=п; t=д, t'=т; ts=з, ts'=ц. Орчин үед Уэйдийн системийг сайжруулаад толь бичиг, мэргэжлийн бүтээлүүд, өдөр тутмын хэвлэл, уран зохиол зэрэг бүх салбарт өргөн ашиглаж байна.

Хятад үгийг францаар галиглах системийн онцлог гэвэл англиийн ch, ch'-ийн оронд tch, tch'-г (tchao=chao=жао, tch'ao= ch'ao=чао), англиийн sh-ийн оронд ch-г (chen=shen=щэнь) хэрэглэнэ. Англиийн u-г ou-гаар (sou=su=сү), англиийн ua-г oua эсвэл oa-гаар (houa, hoa=hua=хуа) орлуулан хэрэглэнэ. Хятад үгийг галиглах францын хамгийн түгээмэл BEFEO системийг Висьер (Vissiere) зохиосон бөгөөд энэ системийг "Францын алс дорнодын сургуулийн мэдээ бичигт" ("Bulletin d'Ecole Francaise d'Extreme Orient" гэдгийг товчлон BEFEO гэв) бага сага засварлан хэвлүүлснээр өргөнөөр хэрэглэх болжээ.

Хятад үгийг германаар галиглах системийн онцлог гэвэл хятадын дуутай болон дуугүй гийгүүлэгчийг хятадын бүх латинчилсан авианы цагаан толгойд байдгийн адилаар тусгай үсгээр ялган тэмдэглэсэн байдаг. Энэ нь: b=б, p=п; g=г, k=к; d=д, t=т; ds=з, ts=ц гэх мэт. Цаашилбал ao (tao, pao, lao г.м.) төгсгөлтэй үеийн хос эгшгийн хоёрдугаар бүтвэрийг англи, франц галигт байдаг шиг o-гоор биш u үсгээр (au=ao=ao; lau=lao=лао; mau=mao=мао) тэмдэглэдэг байна. Түүнээс гадна герман хэлний зөв бичих зүйн дүрмийн онцлогоос шалтгаалсан ялгаатай зүйл бий. Тэр нь: шүргэх дуугүй гийгүүлэгч ш-ийг sch-ээр (schan=shan=щань), аффрикат ч-г tsch-ээр (tschang=ch'ang=чан) тэмдэглэнэ. Зарим системд заримдаг эгшгийг j-гээр (jan=yan=янь) тэмдэглэдэг зэрэг ялгаатай зүйлс бий. Хятад үгийг галиглах германы үндсэн систем бол германы шинэ галиг болон Лессинг-Отмерийн (Lessing-Othmer) галиг болно. Мөн бас Вильгельмийн (Wilhelm) систем ч нэлээд дэлгэр хэрэглэгддэг байна.

Хятадууд ч эртний түүхт энэ бичгээ авиа зүйн латинчилсан цагаан толгойд шилжүүлэх ажлыг XX зуунд хийж эхэлсэн юм. Үүнд:

1. Гөюй ломазы (Gwoyeu Romatzyh). Хятадын латинчилсан цагаан толгойн анхны хувилбар нь 1918 онд гарчээ. Үүний эцсийн хувилбарыг 1926 онд Чянь Шюаньтүнь, Ли Жиньши, Жао Юаньрэнь тэргүүтэн эрдэмтэд боловсруулж, 1928 оноос хэрэглээнд оруулсан байна. Гөюй ломазыгийн онцлог гэвэл үе болгоны дөрвөн хөгийг ялган тэмдэглэх явдал байв. Жишээлбэл, ай гэдэг үеийг ai (нэгдүгээр хөг), air (хоёрдугаар хөг), ae (гуравдугаар хөг), ay (дөрөвдүгээр хөг). Гөюй ломазы галигт хэрэглэгддэг r үсэг нь хятад үгэнд тохиолддог [з] авиаг тэмдэглэхээс гадна гадаад үгэнд тохиолддог [r] авиаг тэмдэглэх бөгөөд энэ тохиолдолд [l]

гэж дуудагдана. Гадаад үгэнд тохиолддог ra, re, ri, ro, ru үеийг хятадаар la, le, li, lo, lu гэж тус тус дуудна.

2. Латинхуа (Latinhua, Latinxua). Хятадын латинчилсан энэ цагаан толгойг 1930 оны эхээр Чюй Чюбө, Ү Юйжан, Эми Шяо (Шяо Сань) нар зөвлөлтийн мэргэжилтнүүдийн хамтаар зохиожээ. Энэ латинхуа цагаан толгойг Зөвлөлт Холбоот Улсад цагаачлан гарсан хятад хүмүүсийн сургалтанд өргөн ашиглаж байжээ. Энэ цагаан толгойг Хятадын чөлөөлөгдсөн нутгуудад хэдэн жил хэрэглэж байв. ЗСБНХУ болон Хятадад латинхуа ашигласан зүйлс хэвлэгдэж байжээ.

3. **Хятадын авиа зүйн шинэ цагаан толгойг** 1958 оны хоёрдугаар сард Бээжинд Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн хурлын V хуралдаанаас баталсан байна. Энэ шинэ цагаан толгойг гаргахдаа урьд өмнөх латинчилсан (гөюй ломазы, латинхуа), хятад үгийг гадаадынхан хэрхэн галиглаж ирсэн туршлагыг харгалзан үзэж зохиожээ. Энэ галиг нь латин хэлний 26 үсгийг бүгдийг ашигладаг бөгөөд зөвхөн v үсэг нь хятад бус гадаадын нэрийг галиглахад хэрэглэгддэг байна. Цорын ганц ялгах тэмдэг нь хэрэглэсэн нь үе бүтээх эгшиг у: бөгөөд ийм эгшиг орсон таван тохиолдол бий. Энэ нь: l\(люй), l=an (люань), l\e (люэ), n= (нюй), n=e (нюэ). Хятад хэлний j, q, x гийгүүлэгчийн дараа орсон u үсгийн дээр ялгах тэмдгийг хэрэглэдэггүй байна. Жишээ нь: ju (жюй), quan (чюань), xue (шюэ). Шаардлагатай үед хөг тэмдэглэх тэмдгийг хэрэглэж болно. Үеийн заагийг апостроп тэмдгээр ялгах тохиолдол байна. Жишээлбэл, fan'gan – фаньгань, fang'an – фанъань, xi'an – шиань, гэвч xian – шянь гэж буулгана.

Хятад үгийг оросоор галиглахын тухайд бол энд аль эртнээс нааш Палладий (П.И.Кафаровын) галигийг зарим нэг засвар нэмэлт оруулан ашигласаар ирсэн байна. Палладийн уламжлалт галигт янз бүрийн үед дараахь өөрчлөлтүүдийг оруулсан байна.

1. люе, нюе, сюе, цзюе, цюе, юе гэж бичиж байсан үеийг люэ, нюэ, сюэ, цзюэ, цюэ, юэ болгон тус тус сольсон.

2. ио, лио, нио, сио, цзио, цио гэж бичиж байсныг халж оронд нь юэ, люэ, нюэ, сюэ, цзюэ, цюэ гэж бичих болсон.

3. мэн – мын, мэнь – мынь, фэн – фын, фэнь – фынь, пэн – пын гэх мэт хоёр янзаар галиглаж байсан зарим үеийг нэг янзаар галиглах болсон. Энэхүү солилтоо цаг хугацааны дарааллаар гурван үе шаттай сольсон болно.

мын, мынь, фын, фынь, пэн гэдэг бичлэгийг хадгалах маягаар

мын, мынь, фын, фэнь, пэн гэдэг бичлэгийг хадгалах маягаар

мэн, мэнь, фэн, фэнь, пэн гэдэг бичлэгийг хадгалах маягаар ээлж дараалан сольж ирсэн байна. Үүний анхны хувилбар нь нэлээд удаан хэрэглэгдэж байгаад 1950 оноос эхлэн үе бүтээх э эгшгийг илүүтэй хэрэглэх болсноор эхлээд хоёрдахь бичлэгийн маяг дараа нь гуравдахь бичлэгийн маяг тогтсон байна.

Хятад хэлний авиаг, үгийг монгол бичгээр галиглах тогтоолцоот уламжлалт арга байгаа хэдий ч шинэ кирилл үсгээр галиглах арга нэг мөр болж тогтоогүй явсаар ирсэн байна. Манай толь бичгүүдэд газар зүйн нэр томъёог оросууд хэрхэн галиглаж байсныг дагах хандлагатай явж ирсэн гэж хэлж болно.

Хятад хэлний авиаг галиглах талаар 1996 онд Хэрээд Лхамсүрэнгийн Жамсраны эмхтгэн гаргасан «Хятад, англи, орос, монгол бичгээр хятад үг галиглах харьцуулсан лавлах» бяцхан гарын авлага гарсан байна. Энэ гарын авлагын өмнөх үгэнд эмхтгэгчээс бичсэнийг үзвэл "Хятад хэлний авиаг нэг мөр болгон тэмдэглэж чаддаг орос галигийн бүх үсэг нь монгол улсад хэрэглэгдэж буй кирилл бичигт байгаа учир манай уншигчид түүнийг өргөн хэрэглэх бололцоотой. Нөгөө талаар хятад авиаг монгол кирилл үсгээр нэг мөр болгон тэмдэглэх галиг зохиогдоогүй, хятад монгол толь хараахан гараагүй байна" гэж бичжээ. Үүнээс үзвэл хятад авиаг монгол шинэ үсгээр нэг мөр болгон тэмдэглэх галиг зохиогдоогүй учир орос галигийг өргөн ашиглахыг уриалсан гэлтэй болжээ. Энэ санааг батлах мэт үгс ч уг өмнөх үгийн 7 дугаар талд дахин гарсан байна. Энэ нь: "Манай зарим хэвлэлд хятад нэрийн галигт ордог дараалсан хоёр гийгүүлэгчийн эхнийхийг орхиж, зөвхөн хоёр дахийг бичдэг нь уг нэрийн дуудлагыг хазгай болгодог. Дараалсан хоёр гийгүүлэгч аль ч хэлний хятад нэрийг галигт байдаг тул түүнээс зайлсхийх хэрэггүй. Харин алинд нь хэрхэн тэмдэглэснийг ажиглаж, яаж дуудахыг дээр хийсэн тайлбараас мэдэж эзэмшвэл зохино. Аль ч улсын бичиг өөрийн хэлний онцлогийг харгалзсан байдаг тул харь хэлний үг бүхнийг уг хэлэнд нь яаж дууддагтай адил тийм нарийн тэмдэглэх бололцоогүй. Иймд орос галиг ч гэсэн хятад хэлний авиа бүхнийг, жирийн уншигч ямар ч мадаггүй зөв дуудахуйцаар тэмдэглэж чадаагүй нь мэдээж билээ" гэжээ. Энд гарч буй "дээр хийсэн тайлбар" гэдэг нь хятад авиаг оросоор галигласныг монголоор хэрхэн зөв дуудахыг тайлбарласан 7 зүйлийн тайлбараа хэлсэн хэрэг юм. Үүнийг ойлгомжтой болгох үүднээс мөн сийрүүлэн бичье.

Хэрээд Л.Жамсраны тайлбар нь: "Иймд орос галигийг монгол хүн уншихад бэрхшээлтэй болов уу гэсэн зарим авиаг хамгийн энгийн ойлгомжтойгоор тайлбарласугай. Үүнд:

1. Харьцуулсан хүснэгтийн 377-396-д байгаа үенүүдийн эхний давхарласан гийгүүлэгч бол "ж"-гийн төрлийн авиаг тэмдэглэхэд ордог. Үүнийг хэлэхэд "ч" үсэг огт дуудагдахгүй. Харин хэлний үзүүр тагнайд хүрэх ба уушигнаас гарсан хийн түрлэг нь хэлний үзүүр тагнай хоёрын завсраар огцом гарна.

2. Хүснэгтийн 130-143-д байгаа үенүүдийн эхний давхарласан гийгүүлэгч бол "з", "ж"-гийн төрлийн авиаг тэмдэглэхэд ордог, хэлэхэд "ц" үсэг огт дуудагдахгүй, харин "з", "ж"-ийн аль болохыг ард нь орсон эгшгээр ялгаж болно. Үүнд: а, о, у, ы, э эгшгүүд ард нь орсон байвал "ж" авиаг тэмдэглэдэг. Үүнийг хэлэхэд хэлний дунд бие тагнайд хүрч, үзүүр нь доод үүдэн шүдэнд тулах бөгөөд уушигны хийн түрлэг хэлний дунд бие тагнай хоёрын завсраар тэсрэн гарна.

3. Хүснэгтийн 48-55, 130-143, 248-261, 397-404-д байгаа үенүүдийн эхний гийгүүлэгч үсэг а, у, о, ы, э эгшгүүдийн өмнө орвол "ц"-ээр дуудагдана. Хэрэв е, и, ю, я-гийн өмнө орвол "ч"-ээр дуудагдана. Иймд "ч"-г дуудахдаа хэлний үзүүрийг доод үүдэн шүдний ёзоорт байлгаж дууддаг.

4. Хүснэгтийн 277-331, 340-353-д байгаа үенүүдийн эхний гийгүүлэгч и, е, ю, я-гийн урд орвол "ш"-тэй ойролцоо дуудагддаг. Тэгэхэд хэлний үзүүрийг доод үүдэн шүдний

ёзоорт байлгаж дууддаг. Бусад тохиолдолд "с"-ээр дууддаг.

5. Хүснэгтийн 262-276-д байгаа үенүүдийн эхний гийгүүлэгчийг дуудахад хэлний үзүүр матийж тагнайд хүрэх тул монгол хэлний "ж" үсгээс ялгаатай, харин ч "р" үсэгтэй ойролцоо дуудагдана.

6. Үгийн дараа ордог "нь" бол монгол хэлний зөөлөрсөн "н"-тэй адил дуудагдана.

7. "У" бол монгол хэлний "у" биш "ү" юм. Эдгээр зүйлийг сайтар анхаарч дуудвал хятад нэр томъёог нэлээд дөхүү хэлж чадна" гэжээ.

Энэ тайлбар нь хятад авиаг оросоор галигласныг монгол хүн хэрхэн хятад хэлэнд ойртуулан дуудах тухай зөвлөмж байна. Бид тэгэхлээр хятад хэлийг орос хэлээр дамжуулан сурах гэж байгаатай ижил зүйл болсон гэж бодож байна. Хэрээд Л.Жамсраны эмхтгэсэн "Харьцуулсан лавлах" нь хятад авиа, үгийг монгол шинэ үсгээр хэрхэн галиглах асуудлыг шууд орхин, орос галигт дулдуйдан дуудахыг заасан төдийгөөр хязгаарласан байна. Уг нь бидэнд хятад авиа, язгуур үеийг монгол бичгийн уламжлалт галигт тулгуурлан шинэ кирилл бичигт хэрхэн зөв буулган галиглах асуудал илүү их чухал санагдах юм.

Хятад хэлний үг, нэрийг хэрхэн галиглан бичих тухай урд өмнө бичиж байгаагүй биш, энэ талаар шинэ үсгийн дүрмийг зохиосон Ц.Дамдинсүрэн гуайн бичиж үлдээсэн зүйл түүний гэр музейн сан хөмрөгт хадгалагдаж байна. Ц.Дамдинсүрэн гуай шинэ үсгийн дүрмийг аль 1940 оны эхээр зохиосон бөгөөд энэ шинэ үсгийн дүрмийг практикт нэвтрүүлэн Монгол улсын хүн амыг бараг бүхлээр бичиг үсэгт тайлагдах үйлд их хувь нэмэр оруулсан юм. Энэ дүрмийг сайжруулах ажлыг 1950, 1960, 1970, 1980 онуудад үргэлжлүүлэн хийж байсан юм. Ц.Дамдинсүрэн гуай 1964 онд «Шинэ үсгийн дүрэм» /төсөл/ гэсэн олон хуудас төслийг шинэчлэн боловсруулж тухай үеийн Намын Төв хорооны үзэл суртлын даргад өргөн барьж толилуулсан дүрэм нь тэр даргын ширээнээ дарагдаж батлагдсан зүйлгүй өнгөрч байжээ. Уг төслийн дотор хятад нэр, үгийг галиглах тухай арван зүйлтэй дүрэм орсон байна.

Энэ төслийн нэг хэсэг нь гадаад хэлний үгийг монгол үсэгт хэрхэн галиглан буулгах талаар байсан юм. Үүний дотор "Хятад газар зүйн ба хүний нэрийг бичих тухай" гэсэн гарчигт 257-оос 266 дугаар зүйлд хятад газар зүйн ба хүний нэрийг монгол хэлнээ хэрхэн буулгах дүрмийг өгүүлсэн болно. Үүнийг сийрүүлбэл:

«257. Хятад хэлнээс монгол хэлэнд орсон аж байдлын ерийн үгийг монгол дуудлагаар уншиж, монгол үсгийн дүрмээр бичиж байх тухай урьд нэгэнтээ хэлсэн билээ. Одоо хятад газар зүйн оноосон нэр, хүний овог нэрийг яаж бичих тухай үгүүлэх болно.

Хятад газар зүйн нэр, хүний нэрийг бичихэд:

1. Оросоор хятад нэрийг бичдэг заншил,
2. Бэйжин аялгуу,
3. Хятадын шинэ латинчилсан авианы үсэг, - энэ гурвыг удирдамж болгоно.

258. Оросоор дамжиж ирсэн гадаад үгийн У үсгийг У Ү хоёр үсгээр тэмдэглэсний адилаар, хятад үсгийг бичихдээ мөн У Ү хоёр үсгийг хэрэглэнэ. Хятад хэлний язгуур үг нь ганц үеэр бүтсэн байдаг тул У Ү хоёр үсгийг ялгаж бичих нь европ зүгийн гадаад үгийг бичихээс хялбар болно.

259. Хятад үгийг бичихэд А /Я/ эгшигтэй нийлж хос эгшиг болсон газарт У үсгийг

бичнэ. Жишээ нь: Гуанси муж, ляньхуа цэцэг гэх мэт.

260. Дангаар үе бүтээсэн ба Ө-тэй нийлж хос эгшиг болсон газарт цөм Ү үсгийг бичнэ. Жишээ нь: Ү Сүнь-фү, Жү Дэ, Шаньдүн муж, Үхань хот, Чанчүнь хот гэх мэт.

261. Хятад хэлний О эгшгийг цөм Ө эгшгээр бичнэ. Жишээ нь: Гө Мө-жъө, Гүнхэгө /ард улс/гэх мэт. Гагцхүү А-тай нийлж хос эгшиг болсон газарт О үсгийг бичнэ. Жишээ нь: бао /сонин/, ляо гэх мэт.

262. Оросоор ЧЖ, ЦЗ гэж бичдэг гийгүүлэгчийг монголоор Ж, З гэж дан үсгээр тэмдэглэнэ. Жишээ нь: Чжэньцзян, Синьцзян гэж бичдэгийг монголоор Жэньзян, Синьзян гэж бичнэ.

263. Оросоор Ж гэж бичдэг ба хятад шинэ үсгээр R гэж бичдэг авиаг монголчууд ЖЪ гэж бичнэ. Жишээ нь: Жъэньминь-жъибао, Жүнгө гүнжъэнь сэтгүүл, Жъэхэ хот гэх мэт.

264. Хятад хүний нэрийн эхний үг овог байдаг, дараах нэг буюу хоёр үг нь чухам нэр байдаг. Иймд эхний овгийг том үсгээр эхэлж бичнэ. Дараах нэрийг мөн том үсгээр эхэлж бичнэ. Хэрэв нэр нь хоёр үсгээс бүтсэн байвал хооронд нь богино зураас тавьж сүүлийн үгийг жижиг үсгээр эхэлж бичнэ. Жишээ нь: Дэн Жүн-ся, Ван Ань-ши, Ван Чуан-шань, Ван Вэй гэх мэт.

Хааяа хятад хүний овог хоёр үеэс бүтсэн байдаг. Тийм овгийг хамт бичнэ. Жишээ нь: Жүгэ Лян, Сыма Цянь гэх мэт.

265. Хятадын хоёр гурван үг буюу үеэс бүтсэн нэрийг хамт бичнэ. Жишээ нь: Ганьсү муж, Гуанжөү хот, Тайюань хот, Тяньзинь хот, Шанхай хот, Жүнхуа Жъэньминь Гүнхэгө /Дундад Ард Улс/ гэх мэт. Үгийг тусгай буюу хамт бичих тухайд хятад шинэ үсгийн бичлэгийг мөрдлөг болгоно.

266. Хятад үгийг монголоор бичихэд баримжаа болох хятад хэлний язгуур үгийн үеийг мэдэх хэрэгтэй. Иймийн тул хятад үгийн язгуур үеийг жагсаая:» гэжээ.

Энэ сүүлийн зүйлд өгүүлсэн жагсаалтыг “Хятад хэлний язгуур үеийг хятад, монгол, орос, англи, франц, германиар галиглах харьцуулсан хүснэг” гэдгийн дотор тусгай багана болгон “1964 оны” гэсэн нэрээр оруулсан тул тэндээс үзэж сонирхоно уу.

Энэ бүгдээс үзэхэд хятад хэлний авиа болон язгуур үеийг монгол шинэ үсгээр галиглах боломж байгаа нь харагдаж байна. Бид энэ удаа хятадын язгуур үеийг монгол, орос, англи, франц, германиар галиглах харьцуулсан хүснэгийг саңал болгож байна. Энэ харьцуулсан хүснэгийг хийхэд:

1. Хятадын авиан зүйн шинэ галиг
2. Хятад хэлний Бээжин аялгуу
3. Хятад хэлний авиаг монгол бичгээр галигладаг систем энэ гурван зүйлийг удирдамж болгов.

Хятад хэлний авиа, язгуур үеийг монгол кирилл үсгээр галиглах шинэ системыг үндсэндээ 2000 онд боловсруулсан учир үүнийг харьцуулсан хүснэгийн есдүгээр баганад “2000 оны” гэсэн нэрээр оруулсан болно.

Галиглах энэ шинэ системд Ц.Дамдинсүрэнгийн “Шинэ үсгийн дүрмийн” төслийн 258-262 дугаар зүйлд өгүүлсэн дүрмийн заалтыг үндэс болгон авсан болно. Харин уг дүрмийн 263 дугаар зүйлд “Оросоор Ж гэж бичдэг ба хятад шинэ үсгээр R гэж бичдэг авиаг монголчууд ЖЪ гэж бичнэ. Жишээ нь: Жъэньминь-жъибао, Жүнгө гүнжъэнь сэтгүүл, Жъэхэ хот гэх мэт”

гэж өгүүлсэн хятадын энэ гийгүүлэгчийг сүүлийн үед монгол бичгийн галигт r гэсэн гийгүүлэгчээр дамжуулан галиглах болсон тул Ц.Дамдинсүрэн гуайн галигийн ЖЪ-г бид Р-ээр сольж галиглав. Жишээ нь: Жъэньминь-жъибао гэхийг Рэньминь рибао гэнэ.

Ц.Дамдинсүрэнгийн дээрх дүрмийн 264 дүгээр зүйлд заасан "Хятад хүний нэрийн эхний үг овог байдаг, дараах нэг буюу хоёр үг нь чухам нэр байдаг. Иймд эхний овгийг том үсгээр эхэлж бичнэ. Дараах нэрийг мөн том үсгээр эхэлж бичнэ. Хэрэв нэр нь хоёр үсгээс бүтсэн байвал хоорондх нь богино зураас тавьж сүүлийн үгийг жижиг үсгээр эхэлж бичнэ. Жишээ нь: Дэн Жүн-ся, Ван Ань-ши, Ван Чуан-шань, Ван Вэй гэх мэт" энэ дүрмийн сүүлийн өгүүлбэрт байгаа "хооронд нь богино зураас тавьж" гэдгийг авч, "Хэрэв нэр нь хоёр үсгээс бүтсэн байвал сүүлийн үгийг жижиг үсгээр бичиж эхний үед шууд залган бичнэ. Жишээ нь: Дэн Жүншя, Ван Аньщи, Ван Чуанщань, Ван Вэй гэх мэт" гэсэн өөрчлөлтийг оруулж байна.

Бидний санал болгож буй галигийн харьцуулсан хүснэгийн 111-129-т байгаа үенүүд нь хятадын авиа зүйн шинэ галигт бүгд h гэсэн гийгүүлэгчээр эхэлж буй үе юм. Үүнийг монгол бичгээр галиглахдаа арга билгээр буюу эр эм гийгүүлэгчээр ялган галигласан тул бид түүнийг дагаж 120, 122, 127, 128-т байгаа "hong – ᠬᠣᠩ, hu – ᠬᡠ, hui – ᠬᡠᡳ, hun – ᠬᡠᠨ" эдгээр үеийг "хун, ху, хуй, хунь" тус тус галигласан болно.

Харьцуулсан хүснэгт хятад хэлний bo, chuo, cuo, duo, fo, guo, huo, kuo, luo, mo, nuo, o, po, ruo, shuo, suo, tuo, zhuo гэсэн үенүүдийн o, uo гэсэн авиа, хос авиаг монгол бичигт ᠣᡠ гэсэн үсгийн нийлэмжээр тэмдэглэдэг байна. Үүнийг орос галиг о үсгээр дамжуулан галигладгийг бид Ц.Дамдинсүрэнгийн дүрмийн 261 дүгээр заасан "хятад хэлний О эгшгийг цөм Ө эгшгээр бичнэ" гэсний дагуу ө үсгээр галигласан болно.


Харьцуулсан хүснэгийн 130-143-т байгаа үенүүд хятад галигт ji гэж, монгол бичгийн галигт мөн адил Ji гэж байгаа тул оросын галигийн цзи, Ц.Дамдинсүрэнгийн зи гэснийг бол жи гэж галиглав. Жишээлбэл, цзи-зи-жи, цзя-зя-жя, цзянь-зянь-жянь, цзинь-зинь-жинь гэх мэт.

Харьцуулсан хүснэгийн 250-263-т байгаа үенүүд хятад галигт "qi" үеэр эхэлж байгаа бөгөөд үүнийг монгол бичгийн галигт бүгдийг "сі"-гээр галиглаж байгаа тул монгол бичгийн дагуулан "чи"-гээр буулгасан болно. Жишээ нь: ци-ци-чи, ця-ця-чя, цянь-цянь-чянь, цян-цян-чян, цяо-цяо-чяо, цюэ-цюэ-чюэ гэх мэт.

Энд бас харьцуулсан хүснэгийн 38-т байгаа хятад галигийн "chi" гэсэн үеийг монгол бичгийн галигт ooI гэж уламжлалт аргаар ялган галигласныг бид бас чи-гээр галигласан болно.

Харьцуулсан хүснэгийн 287-303-т байгаа хятад галигийн sh-ийг монгол бичгийн галигт Z гэж ш-ийг с-ээс ялгасан тэмдэг бүхий үсгээр галигласан тул бид үүнийг кирилл бичгийн цагаан толгойн зөвхөн гадаад үгэнд хэрэглэгддэг щ-гээр ялган галигласан юм. Жишээлбэл, хятадын shan нь монгол бичигт Zea, монгол кирилл үсгээр щань, оросоор шань болно. Хятад хэлний ш гэсэн авиаг нэгэнт щ гэсэн үсгээр ялган галигласан тул харьцуулсан хүснэгийн 342-355-т байгаа хятадын xi, xia, xian, xiang, xiao, xie, xin, xing, xiong, xiu, xu,

xuan, xue, xun гэсэн үенүүдийг монгол бичигт



гэж галигласныг монгол кирилл үсэгт ши, шя, шянь, шян, шяо, ше, шинь, шин, шюн, шю, шюй, шюань, шюэ, шюнь гэж галиглах боломжтой гэж үзэв. Эдгээр үеийг орос галигийн си, ся, сянь, сян, сяо, се, синь, син, сюн, сю, сюй, сюань, сюэ, сюнь-тэй харьцуулан үзнэ үү. Бидний санал болгож галигийн систем нь монгол бичгийн галигийн үсэг ялгах боломжийг шинэ үсэгт авч хэрэглэхийг зорьсон болно.

Эцэст нь тэмдэглэн хэлэхэд хятад хэлний өзгуур үе, үгийг монгол бичигт бүрэн тэмдэглэх бололцоог 1587 онд Харчины Аюуш гүүшийн санскрит, төвд, хятад зэрэг харь хэлний үгийг зөв тэмдэглэх шаардлагын үүднээс зохиосон "Али гали" хэмээх галиг үсэг олгож байгаа билээ. Иймээс энэ "али гали" галиг үсэг, монгол бичгийн зурлагын ялгах чадамжинд тулгуурлан хятадын язгуур үеийг монголын орчин цагийн кирилл бичгээр буулгах бүрэн боломж бололцоо байна гэж үзсэн юм. Тэгэхдээ дээр Хэрээд Л.Жамсраны тэмдэглэсэн "аль ч улсын бичиг өөрийн хэлний онцлогийг харгалзсан байдаг тул харь хэлний үг бүхнийг уг хэлэнд нь яаж дууддагтай адил тийм нарийн тэмдэглэх бололцоогүй" бөгөөд бид хятад хүн *яаж дууддагийг монголын кирилл* үсгээр гаргах зорилт өмнөө тавиагүй билээ. Үүнд нэг анхаарах зүйл бол хятад хэлний n гийгүүлэгчээр төгссөн үеийг оросын галигт нь гэж буулгадаг нь угтаа хэлний үзүүрийн н-ийг ялгасан санаа бөгөөд эртний хятадын 汉 улсыг монгол бичигт Неа гэнэ. Үүнийг оросоор хань гэж буулгадгийг бид мөн хань *гэж монгол кирилл* үсэгт буулгасан болно. Монгол хүн үүнийг уншихдаа зөөлрүүлэн дуудах гээд байдаг нь хятад хүний дууддагаас хэтэрхий зөөлрүүлэн хэлдэг байна. Энэ дашрамд өгүүлэхэд Ж.Төмөрцэрэн гуай цагтаа энэ хань гэдэг үгийг монгол хэлний хана гэдэг үгийг дуудахад монгол яаж хэлдэг тэр янзаар дуудах, мөн бичиж галиглах тухай санал бичиж байсан нь бий.

Энэ галиглах системийг бид 2000 оны үед боловсруулсан бөгөөд хятад нэр, үгсийг галиглах энэхүү аргачлалыг хэрэглэж "Гурван-Эрдэнэ" дээд сургуулийн багш М.Алтанчимэг XIX зууны алдарт зохиолч В.Инжиннашийн «Нэгэн давхар асар» (2002), «Улаанаа уйлах тэнхим» (2003) зэрэг романыг монгол бичгээс кирилл үсэгт буулгахдаа хэрэглэсэн болно. Мөн ШУА-ийн Хэл Зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Болормаа, Б.Гэрэлтийн эмхтгэсэн «Монгол зохиолчдын шүүмж өгүүлэл. /1721-1945/» (1981/1985) номыг монгол бичгээс кирилл бичигт буулгахдаа хятад нэр, үгсийг энэ системийн дагуу буулгасан бөгөөд удахгүй хэвлэгдэн гарах гэж байна.

Бид «Хятадын язгуур үеийг монгол, орос, англи, франц, германиар галиглах харьцуулсан хүснэг»-тээ БНХАУ-ын засаг захиргааны нэгж, хятад газар зүйн нэр үгэнд ордог зарим үгс, хятад *хүний хоёр үеэс* бүтсэн овгийн нэрс зэргийг дагалдуулал болгон хятад авиа, үгсийг хэрхэн галигласнаа үлгэрлэн үзүүлэв.

АШИГЛАСАН НОМ:

1. Ц.Дамдинсүрэн. Шинэ үсгийн дүрэм. /Төсөл/ УБ., 1964. /Ц.Дамдинсүрэнгийн гэр музейд хадгалагдаж буй номын машиндсан эх/
2. Хэрээд Л.Жамсран. Хятад, англи, орос, монгол бичгээр хятад үг галиглах харьцуулсан лавлах. УБ., 1996.
3. С.А.Мацаев, В.Г.Орлов. Пособие по транскрипции и право писанию китайских слов. Москва, 1966.
4. Ч.Нэргүй.Босоо бичиг. УБ., 2004.
5. Б.Ринчен.Монгол бичгийн хэлний зүй. УБ., 1964, 99-102-р тал.
6. Д.Төмөртогоо.Монгол хэл шинжлэлийн түүхэн уламжлал ба онолын үндэс. –“Хэл зохиол судлал” XVII боть, 40-ртал.
7. Хятад үсгийн үеийг монголоор харшуулан тэмдэглэсэн хүснэгт. —汉蒙词典Хятад монгол толь. Дөрөвдэх хэвлэл. Хөххот, 1999, 2226-2240-р тал.
8. Л.Чулуунбаатар. Нүүдэлчин монголчуудын бичиг үсгийн соёл. УБ., 2002.
9. Ц.Шагдарсүрэн. Монгол үсэгзүй. УБ., 1981.

ХЯТАД ХЭЛНИЙ ЯЗГУУР ҮЕИЙГ МОНГОЛ, ОРОСООР ГАЛИГЛАХ ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

№	ХЯТАД ХЭЛНИЙ ЯЗГУУР ҮЕ		МОНГОЛ					ОРОС	
	Жишээ ханз	Авианы галиг		Эхэнд	Дунд	Адагт	1964 оны	2000 оны	
1.	啊	a					а	а	а
2.	艾	ai					ай	ай	ай
3.	安	an					ань	ань	ань
4.	仰	ang					ан	ан	ан
5.	傲	ao					ао	ао	ао
6.	爸	ba					ба	ба	ба
7.	白	bai					бай	бай	бай
8.	班	ban					бань	бань	бань
9.	帮	bang					бан	бан	бан
10.	宝	bao					бао	бао	бао
11.	北	bei					бэй	бэй	бэй
12.	奔	ben					бэнь	бэнь	бэнь
13.	进	beng					бэн	бэн	бэн
14.	笔	bi					би	би	би
15.	变	bian					бянь	бянь	бянь
16.	表	biao					бяо	бяо	бяо
17.	别	bie					бе	бе	бе
18.	宾	bin					бинь	бинь	бинь
19.	冰	bing					бин	бин	бин
20.	泊	bo					бө	бө	бо
21.	布	bu					бү	бү	бу
22.	擦	ca					ца	ца	ца
23.	财	cai					цай	цай	цай
24.	灿	can					цань	цань	цань
25.	藏	cang					цан	цан	цан
26.	曹	cao					цао	цао	цао
27.	侧	ce					цэ	цэ	цэ
28.	参	cen					цэнь	цэнь	цэнь
29.	层	ceng					цэн	цэн	цэн
30.	茶	cha					ча	ча	ча
31.	柴	chai					чай	чай	чай
32.	掺	chan					чань	чань	чань
33.	唱	chang					чан	чан	чан
34.	朝	chao					чао	чао	чао

35.	车	che					чэ	чэ	чэ	75.
36.	臣	chen					чэнь	чэнь	чэнь	76.
37.	称	cheng					чэн	чэн	чэн	77.
38.	持	chi					чи	чи	чи	78.
39.	充	chong					чүн	чүн	чун	79.
40.	稠	chou					чөү	чөү	чоу	80.
41.	初	chu					чү	чү	чу	81.
42.	欻	chua					чуа	чуа	чуа	82.
43.	揣	chuai					чуай	чуай	чуай	83.
44.	传	chuan					чуань	чуань	чуань	84.
45.	窗	chuang					чуан	чуан	чуан	85.
46.	吹	chui					чүй	чүй	чуй	86.
47.	春	chun					чүнь	чүнь	чунь	87.
48.	促	chuo					чө	чө	чо	88.
49.	瓷	ci					цы	цы	цы	89.
50.	聪	cong					цүн	цүн	цун	90.
51.	凑	cou					цөү	цөү	цоу	91.
52.	醋	cu					цү	цү	цу	92.
53.	窜	cuan					цуань	цуань	цуань	93.
54.	摧	cui					цүй	цүй	цуй	94.
55.	村	cun					цүнь	цүнь	цунь	95.
56.	错	cuo					цө	цө	цо	96.
57.	大	da					да	да	да	97.
58.	带	dai					дай	дай	дай	98.
59.	耽	dan					дань	дань	дань	99.
60.	当	dang					дан	дан	дан	100.
61.	岛	dao					дао	дао	дао	101.
62.	德	de					дэ	дэ	дэ	102.
63.	咄	dei					дэй	дэй	дэй	103.
64.	灯	deng					дэн	дэн	дэн	104.
65.	帝	di					ди	ди	ди	105.
66.	电	dian					дянь	дянь	дянь	106.
67.	钓	diao					дяо	дяо	дяо	107.
68.	爹	die					де	де	де	108.
69.	订	ding					дин	дин	дин	109.
70.	丢	diu					дю	дю	дю	110.
71.	东	dong					дүн	дүн	дун	111.
72.	逗	dou					дөү	дөү	доу	112.
73.	读	du					дү	дү	ду	113.
74.	端	duan					дуань	дуань	дуань	114.

75.	队	dui					дүй	дүй	дуй
76.	盾	dun					дүнь	дүнь	дунь
77.	多	duo					дө	дө	до
78.	额	e					э	э	э
79.	诶	ei					эй	эй	эй
80.	恩	en					энь	энь	энь
81.	翰	eng					эн	эн	эн
82.	耳	er					эр	эр	эр
83.	法	fa					фа	фа	фа
84.	翻	fan					фань	фань	фань
85.	访	fang					фан	фан	фан
86.	非	fei					фэй	фэй	фэй
87.	分	fen					фэнь	фэнь	фэнь(фынь)
88.	风	feng					фэн	фэн	фэн (фын)
89.	佛	fo					фө	фө	фо
90.	否	fou					фөү	фөү	фоу
91.	福	fu					фү	фү	фу
92.	尬	ga					га	га	га
93.	改	gai					гай	гай	гай
94.	干	gan					гань	гань	гань
95.	钢	gang					ган	ган	ган
96.	高	gao					гао	гао	гао
97.	歌	ge					гэ	гэ	гэ
98.	给	gei					гэй	гэй	гэй
99.	跟	gen					гэнь	гэнь	гэнь
100.	更	geng					гэн	гэн	гэн
101.	宫	gong					гүн	гүн	гун
102.	够	gou					гөү	гөү	гоу
103.	故	gu					гү	гү	гу
104.	刮	gua					гуа	гуа	гуа
105.	怪	guai					гуай	гуай	гуай
106.	官	guan					гуань	гуань	гуань
107.	光	guang					гуан	гуан	гуан
108.	贵	gui					гүй	гүй	гуй
109.	棍	gun					гүнь	гүнь	гунь
110.	国	guo					гө	гө	го
111.	哈	ha					ха	ха	ха
112.	海	hai					хай	хай	хай
113.	汉	han					хань	хань	хань
114.	航	hang					хан	хан	хан

115.	好	hao					хао	хао	хао
116.	河	he					хэ	хэ	хэ
117.	黑	hei					хэй	хэй	хэй
118.	很	hen					хэнь	хэнь	хэнь
119.	横	heng					хэн	хэн	хэн
120.	红	hong					хун	хун	хун
121.	候	hou					хөү	хөү	хоу
122.	胡	hu					хү	ху	ху
123.	画	hua					хуа	хуа	хуа
124.	划	huai					хуай	хуай	хуай
125.	环	huan					хуань	хуань	хуань
126.	凰	huang					хуан	хуан	хуан
127.	回	hui					хуэй	хуй	хуэй
128.	婚	hun					хүнь	хунь	хунь
129.	货	huo					хө	хө	хо
130.	鸡	ji					зи	жи	цзи
131.	家	jia					зя	жя	цзя
132.	见	jian					зянь	жянь	цзянь
133.	江	jiang					зян	жян	цзян
134.	教	jiao					зяо	жяо	цзяо
135.	节	jie					зе	же	цзе
136.	金	jin					зинь	жинь	цзинь
137.	敬	jing					зин	жин	цзин
138.	窘	jiong					зюн	жюн	цзюн
139.	旧	jiu					зю	жю	цзю
140.	剧	ju					зюй	жюй	цзюй
141.	倦	juan					зюань	жюань	цзюань
142.	决	jue					зюэ	жюэ	цзюэ
143.	军	jun					зюнь	жюнь	цзюнь
144.	咖	ka					ка	ка	ка
145.	开	kai					кай	кай	кай
146.	看	kan					кань	кань	кань
147.	康	kang					кан	кан	кан
148.	靠	kao					као	као	као
149.	科	ke					кэ	кэ	кэ
150.	肯	ken					кэнь	кэнь	кэнь
151.	坑	keng					кэн	кэн	кэн
152.	孔	kong					күн	күн	кун
153.	口	kou					көү	көү	коу
154.	库	ku					кү	кү	ку

155.	跨	kua					куа	куа	куа
156.	快	kuai					куай	куай	куай
157.	宽	kuan					куань	куань	куань
158.	筐	kuang					куан	куан	куан
159.	亏	kui					күй	күй	куй
160.	昆	kun					күнь	күнь	кунь
161.	扩	kuo					кө	кө	ко
162.	蜡	la					ла	ла	ла
163.	来	lai					лай	лай	лай
164.	烂	lan					лань	лань	лань
165.	狼	lang					лан	лан	лан
166.	劳	lao					лао	лао	лао
167.	乐	le					лэ	лэ	лэ
168.	类	lei					лэй	лэй	лэй
169.	愣	leng					лэн	лэн	лэн
170.	离	li					ли	ли	ли
171.	联	lia					ля	ля	ля
172.	练	lian					лянь	лянь	лянь
173.	亮	liang					лян	лян	лян
174.	料	liao					ляо	ляо	ляо
175.	列	lie					ле	ле	ле
176.	林	lin					линь	линь	линь
177.	令	ling					лин	лин	лин
178.	流	liu					лю	лю	лю
179.	龙	long					лүн	лүн	лун
180.	楼	lou					лөү	лөү	лоу
181.	陆	lu					лү	лү	лу
182.	绿	lv					люй	люй	люй
183.	乱	luan					луань	луань	луань
184.		lvan					люань	люань	люань
185.	略	lve					люэ	люэ	люэ
186.	论	lun					лүнь	лүнь	лунь
187.	落	luo					лө	лө	ло
188.	马	ma					ма	ма	ма
189.	麦	mai					май	май	май
190.	满	man					мань	мань	мань
191.	忙	mang					ман	ман	ман
192.	矛	mao					мао	мао	мао
193.	美	mei					мэй	мэй	мэй
194.	门	men					мэнь	мэнь	мэнь (мынь)

195.	梦	meng					мэн	мэн	мэн (мын)
196.	密	mi					ми	ми	ми
197.	绵	mian					мянь	мянь	мянь
198.	庙	miao					мяо	мяо	мяо
199.	咩	mie					ме	ме	ме
200.	民	min					минь	минь	минь
201.	明	ming					мин	мин	мин
202.	缪	miu					мю	мю	мю
203.	摸	mo					мө	мө	мо
204.	某	mou					мөү	мөү	моу
205.	木	mu					мү	мү	му
206.	纳	na					на	на	на
207.	奶	nai					най	най	най
208.	南	nan					нань	нань	нань
209.	囔	nang					нан	нан	нан
210.	脑	nao					нао	нао	нао
211.	讷	ne						нэ	нэ
212.	内	nei					нэй	нэй	нэй
213.	恁	nen						нэнь	нэнь
214.	能	neng					нэн	нэн	нэн
215.	你	ni					ни	ни	ни
216.	年	nian					нянь	нянь	нянь
217.	娘	niang					нян	нян	нян
218.	鸟	niao					няо	няо	няо
219.	陧	nie					не	не	не
220.	您	nin					нинь	нинь	нинь
221.	宁	ning					нин	нин	нин
222.	牛	niu					ню	ню	ню
223.	农	nong					нүн	нүн	нун
224.	耨	nou					нөү	нөү	ноу
225.	努	nu					нү	нү	ну
226.	女	nv					нюй	нюй	нюй
227.	暖	nuan					нуань	нуань	нуань
228.	娞	nve					нюэ	нюэ	нюэ
229.	麝	nun					нүнь	нүнь	нунь
230.	诺	nuo					нө	нө	но
231.	哦	o					ө	ө	о
232.	欧	ou					өү	өү	оу
233.	爬	pa					па	па	па
234.	拍	pai					пай	пай	пай

274.	授	rua	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ		жуа
273.	乳	ru	ꑟꑭ	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑭ	жьыу	ру		жу
272.	肉	rou	ꑟꑭ	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑭ	жьөу	рөу		жоу
271.	茸	rong	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	жьун	рун		жун
270.	日	ri	ꑟꑵ	ꑟꑵ			жьи	ри		жи
269.	仍	reng	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	жьэн	рэн		жэн
268.	人	ren	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	жьэнь	рэнь		жэнь
267.	热	re	ꑟꑵ	ꑟꑵ	ꑟꑵ	ꑟꑵ	жьэ	рэ		жэ
266.	绕	rao	ꑟꑭꑯ	ꑟꑭꑯ	ꑟꑭꑯ	ꑟꑭꑯ	жьао	рао		жао
265.	让	rang	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	жьан	ран		жан
264.	然	ran	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	жьань	рань		жань
263.	群	qun	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	цюнь	чюнь		цюнь
262.	缺	que	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	цюэ	чюэ		цюэ
261.	泉	quan	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	цюань	чюань		цюань
260.	区	qu	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	цюй	чюй		цюй
259.	球	qiu	ꑟꑯ	ꑟꑯ	ꑟꑯ	ꑟꑯ	цю	чю		цю
258.	穷	qiong	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	ꑟꑴꑩꑩ	цюн	чюн		цюн
257.	清	qing	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	цин	чин		цин
256.	琴	qin	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	цинь	чинь		цинь
255.	切	qie	ꑟꑵꑩ	ꑟꑵꑩ	ꑟꑵꑩ	ꑟꑵꑩ	це	чэ		це
254.	桥	qiao	ꑟꑭꑯ	ꑟꑭꑯ	ꑟꑭꑯ	ꑟꑭꑯ	цяо	чяо		цяо
253.	强	qiang	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	ꑟꑴꑩ	цян	чян		цян
252.	千	qian	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	ꑟꑴ	цянь	чянь		цянь
251.	洽	qia	ꑟꑭ	ꑟꑭ	ꑟꑭ	ꑟꑭ	ця	чя		ця
250.	气	qi	ꑟ	ꑟ	ꑟ	ꑟ	ци	чи		ци
249.	扑	pu	ꑡ	ꑡ	ꑡ	ꑡ	пу	пу		пу
248.	掊	pou	ꑞꑭ	ꑞꑭ	ꑞꑭ	ꑞꑭ	пэу	пэу		поу
247.	朴	po	ꑞꑯ	ꑞꑯ	ꑞꑯ	ꑞꑯ	по	по		по
246.	平	ping	ꑞꑴꑩ	ꑞꑴꑩ	ꑞꑴꑩ	ꑞꑴꑩ	пин	пин		пин
245.	品	pin	ꑞꑵ	ꑞꑵ	ꑞꑵ	ꑞꑵ	пинь	пинь		пинь
244.	乒	pie	ꑞꑵꑩ	ꑞꑵꑩ	ꑞꑵꑩ	ꑞꑵꑩ	пе	пэ		пе
243.	漂	piao	ꑞꑭꑯ	ꑞꑭꑯ	ꑞꑭꑯ	ꑞꑭꑯ	пяо	пяо		пяо
242.	便	pian	ꑞꑴ	ꑞꑴ	ꑞꑴ	ꑞꑴ	пянь	пянь		пянь
241.	匹	pi	ꑞꑵ	ꑞꑵ	ꑞꑵ	ꑞꑵ	пи	пи		пи
240.	朋	peng	ꑞꑴꑩ	ꑞꑴꑩ	ꑞꑴꑩ	ꑞꑴꑩ	пэн	пэн		пэн
239.	盆	pen	ꑞꑴ	ꑞꑴ	ꑞꑴ	ꑞꑴ	пэнь	пэнь		пэнь
238.	佩	pei	ꑞꑵ	ꑞꑵ	ꑞꑵ	ꑞꑵ	пэй	пэй		пэй
237.	跑	pao	ꑞꑭ	ꑞꑭ	ꑞꑭ	ꑞꑭ	пао	пао		пао
236.	旁	pang	ꑞꑴꑩ	ꑞꑴꑩ	ꑞꑴꑩ	ꑞꑴꑩ	пан	пан		пан
235.	盘	pan	ꑞꑴ	ꑞꑴ	ꑞꑴ	ꑞꑴ	пань	пань		пань

275.	软	ruan					жъуань	руань	жуань
276.	蚋	rui					жъүй	рүй	жуй
277.	润	run					жъүнь	рүнь	жунь
278.	弱	ruo					жъө	рө	жо
279.	洒	sa					са	са	са
280.	塞	sai					сай	сай	сай
281.	伞	san					сань	сань	сань
282.	桑	sang					сан	сан	сан
283.	嫂	sao					сао	сао	сао
284.	色	se					сэ	сэ	сэ
285.	森	sen					сэнь	сэнь	сэнь
286.	僧	seng					сэн	сэн	сэн
287.	沙	sha					ша	ща	ша
288.	晒	shai					шай	щай	шай
289.	善	shan					шань	щань	шань
290.	上	shang					шан	щан	шан
291.	少	shao					шао	щао	шао
292.	蛇	she					шэ	щэ	шэ
293.	谁	shei					шэй	щэй	шэй
294.	身	shen					шэнь	щэнь	шэнь
295.	省	sheng					шэн	щэн	шэн
296.	十	shi					ши	щи	ши
297.	手	shou					шөү	щөү	шоу
298.	书	shu					шү	щү	шу
299.	刷	shua					шуа	щуа	шуа
300.	甩	shuai					шуай	щуай	шуай
301.	闩	shuan					шуань	щуань	шуань
302.	双	shuang					шуан	щуан	шуан
303.	水	shui					шүй	щүй	шуй
304.	瞬	shun					шүнь	щүнь	шунь
305.	说	shuo					шө	щө	шо
306.	四	si					сы	сы	сы
307.	宋	song					сүн	сүн	сун
308.	搜	sou					сөү	сөү	соу
309.	速	su					сү	сү	су
310.	算	suan					суань	суань	суань
311.	岁	sui					сүй	сүй	суй
312.	孙	sun					сүнь	сүнь	сунь
313.	缩	suo					сө	сө	со
314.	塔	ta					та	та	та

315.	太	tai					тай	тай	тай
316.	弹	tan					тань	тань	тань
317.	唐	tang					тан	тан	тан
318.	套	tao					тао	тао	тао
319.	特	te					тэ	тэ	тэ
320.	腾	teng					тэн	тэн	тэн
321.	体	ti					ти	ти	ти
322.	天	tian					тянь	тянь	тянь
323.	跳	tiao					тяо	тяо	тяо
324.	铁	tie					те	те	те
325.	停	ting					тин	тин	тин
326.	同	tong					түн	түн	тун
327.	头	tou					төү	төү	тоу
328.	土	tu					тү	тү	ту
329.	团	tuan					туань	туань	туань
330.	推	tui					түй	түй	туй
331.	吞	tun					түнь	түнь	тунь
332.	拖	tuo					тө	тө	то
333.	瓦	wa					ва	ва	ва
334.	外	wai					вай	вай	вай
335.	万	wan					вань	вань	вань
336.	王	wang					ван	ван	ван
337.	未	wei					вэй	вэй	вэй
338.	文	wen					вэнь	вэнь	вэнь
339.	翁	weng					вэн	вэн	вэн
340.	我	wo					вө	вө	во
341.	舞	wu					ү	ү	у
342.	西	xi					си	ши	си
343.	夏	xia					ся	шя	ся
344.	县	xian					сянь	шянь	сянь
345.	香	xiang					сян	шян	сян
346.	小	xiao					сяо	шяо	сяо
347.	写	xie					се	ше	се
348.	新	xin					синь	шинь	синь
349.	星	xing					син	шин	син
350.	胸	xiong					сюн	шюн	сюн
351.	绣	xiu					сю	шю	сю
352.	许	xu					сюй	шюй	сюй
353.	选	xuan					сюань	шюань	сюань
354.	学	xue					сюэ	шюэ	сюэ

355.	讯	xun					сюнь	шюнь	сюнь
356.	牙	ya					я	я	я
357.		yai					яй	яй	яй
358.	眼	yan					янь	янь	янь
359.	羊	yang					ян	ян	ян
360.	要	yao					яо	яо	яо
361.	野	ye					е	е	е
362.	一	yi					и	и	и
363.	音	yin					инь	инь	инь
364.	影	ying					ин	ин	ин
365.	永	yong					юн	юн	юн
366.	油	you					ю	ю	ю
367.	雨	yu					юй	юй	юй
368.	元	yuan					юань	юань	юань
369.	月	yue					юэ	юэ	юэ
370.	云	yun					юнь	юнь	юнь
371.	杂	za					за	за	цза
372.	在	zai					зай	зай	цзай
373.	咱	zan					зань	зань	цзань
374.	藏	zang					зан	зан	цзан
375.	早	zao					зао	зао	цзао
376.	责	ze					зэ	зэ	цзэ
377.	贼	zei					зэй	зэй	цзэй
378.	怎	zen					зэнь	зэнь	цзэнь
379.	增	zeng					зэн	зэн	цзэн
380.	眨	zha					жа	жа	чжа
381.	摘	zhai					жай	жай	чжай
382.	站	zhan					жань	жань	чжань
383.	章	zhang					чжан	жан	чжан
384.	找	zhao					жао	жао	чжао
385.	哲	zhe					жэ	жэ	чжэ
386.	這	zhei					жэй	жэй	чжэй
387.	针	zhen					жэнь	жэнь	чжэнь
388.	整	zheng					жэн	жэн	чжэн
389.	只	zhi					жи	жи	чжи
390.	中	zhong					жун	жүн	чжун
391.	周	zhou					жөү	жөү	чжоу
392.	主	zhu					жү	жү	чжу
393.	抓	zhua					жуа	жуа	чжуа
394.	转	zhuai					жуай	жуай	чжуай

395.	专	zhuan					жуань	жуань	чжуань
396.	壮	zhuang					жуан	жуан	чжуан
397.	追	zhui					жүй	жүй	чжуй
398.	准	zhun					жүнь	жүнь	чжунь
399.	桌	zhuo					жө	жө	чжо
400.	字	zi					зы	зы	цзы
401.	总	zong					зүн	зүн	цзун
402.	走	zou					зөү	зөү	цзоу
403.	族	zu					зү	зү	цзу
404.	钻	zuan					зуань	зуань	цзуань
405.	最	zui					зүй	зүй	цзуй
406.	尊	zun					зүнь	зүнь	цзунь
407.	做	zuo					зө	зө	цзо